

БАТЛАВ  
НИЙСЛЭЛИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН  
ГАЗРЫН ДАРГА  
П. БАТХҮЛЭГ

2018 оны 03 сарын 15 өдөр

1116128632

ЗАСГИЙН ГАЗРААС ИРҮҮЛСЭН "АВИЛГЫН ЭРСДЭЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЗӨВЛӨМЖ"-ИЙН  
ДАГУУ 2018 ОНД ХИЙХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2018.03.15

№	Зөвлөмжийн заалт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлж ажиллаж албан тушаалтан
Нэг. Хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийг сайжруулах; ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр			
1	Зөвлөмж 1. Хуульд заасан үндэслэл, журмын дагуу сонгон шалгаруулалт явуулахаас зайлсхийж, төрийн жинхэнэ албан тушаалын ажлын байранд иргэнийг гэрээгээр ажиллуулдаг, Засгийн газраас баталсан бүтцийг өөрчилж, шинээр нэгж байгуулдаг, орон тооны дээд хязгаарыг хэтрүүлсэн албан тушаалтныг томилддог зөрчлийг арилгах	Төрийн жинхэнэ албан хаагчийг томилохдоо төрийн албаны тухай хуулийн холбогдох заалтыг удирдлага болгох Мэргэшлийн шалгалт өгөөгүй, төрийн албаны нөөцөд бүртгэгдээгүй иргэнийг томилох, түр орлон гүйцэтгэгчээр томилох зэрэг зөрчлийг гаргахгүй байх Төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх явцдаа авилга, ашиг сонирхлын зөрчлөлд холбогдвол холбогдох хуулийн дагуу харилцлага хүлээлгэх, аливаа шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцохдоо өөртөө болон бусдад давуу байдал олгох эрсдэлийг бий болгохгүй байх Засгийн газрын 2016 оны 08 дугаар тогтоол, Нийслэлийн засаг даргын 2016 оны А/635 дугаар захирамжаар тус тус баталсан бүтэц орон тоог хэтрүүлсэн томилоо хийхгүй байх	Удирдлага Удирдлага Нийт албан хаагчид
2	Зөвлөмж 3. Засгийн газрын 2011 оны 62 дугаар тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн үүргийг түр орлон гүйцэтгэх журам"-ын хэрэгжилтийг хангуулах	Төрийн байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулах нөхцөлийг хангах зорилгоор төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэхтэй холбогдсон харилцааг журмын дагуу зохион байгуулах	Бодлого төлөвлөлтийн хэлтэс

3	Зөвлөмж 4. Ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолтыг тухайн албан тушаалд томилогдох гэж буй этгээдэд тохируулан боловсруулж байгаа зөрчлийг таслан зогсоох, дахин ийм зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах	Төрийн албаны зөвлөлийн 2004 оны 34 дүгээр тогтоолын 1.4 дэх хэсэгт "Ажлын байрны тодорхойлолтыг ажил эрхлэгчид тохируулах бус, тухайн байгууллагын зорилт, чиг үүргийг үр ашиг, үр нөлөөтэй хэрэгжүүлэх шаардлагатай нийцүүлэн ажлын байрны шинжилгээ, үнэлгээний үр дүнд тулгуурлан боловсруулна." заасныг баримтлан албан хаагчдын ажлын байр/албан тушаал/-ны тодорхойлолтыг боловсруулах	
4	Зөвлөмж 5. Төрийн албанаас чөлөөлөгдсөнөөс хойш 2 жилийн дотор өөрийн ажиллаж байсан салбарын чиглэлээр хуулийн этгээд байгуулах, өөрөө болон түүний гэр бүлийн гишүүдийн үүсгэн байгуулсан, хувь эзэмшсэн, хамтын өмчлөлийн компанитай холбогдохыг хязгаарлах	Төрийн албанаас чөлөөлөгдөхөөр хуссэлт гаргасан үеэс холбогдох хязгаарлалтыг танилцуулах, мөн хуулийн /АЭХ, НАНБХАСЗАСЗУСТХ/ үйлчлэлд хамаардаггүй ажилтан, албан хаагчийг ажиллаж байх хугацаанд нь тухайн салбар, чиглэлийн гэрээ хэлцэл байгуулах, хамтран ажиллахыг хориглох	Нийт албан хаагчид
5	Зөвлөмж 6. Нийтийн албан тушаалтны давхар ажил эрхлэлтэд тавих хяналтыг сайжруулах, гарсан зөрчлийг арилгах, энэ төрлийн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, нийтийн албан тушаалтан үндсэн ажлаасаа гадна хэд хэдэн ажил, үүрэг гүйцэтгэж, эрх эдэлж байгааг хууль тогтоомжид заасан хориглолт, хязгаарлалтын хүрээнд хянан үзэж, холбогдох хууль, журамд нийлүүлэн өөрчлөх, үндсэн ажил, чиг үүргийг нь алдагдуулахгүй байх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 18, 19 дүгээр зүйлд /Давхар ажил эрхлэхтэй холбогдсон хязгаарлалт, Давхар ажил эрхлэхтэй холбогдсон хязгаарлалтыг хэрэгжүүлэх журам/ заасан хязгаарлалтыг хэрэгжүүлэх	Нийт албан хаагчид
6	Зөвлөмж 8. Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэсний төлөө хууль тогтоомжид зааснаас гадуур аливаа төлбөр авахгүй байх, хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд хандив, тусламж авч хууль тогтоомж зөрчих, иргэдийг чирэгдүүлдэг явдлыг таслан зогсоох	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17 дугаар зүйлд /Хандив авахтай холбогдсон хязгаарлалт/ заасан хязгаарлалтыг хэрэгжүүлэх	Нийт албан хаагчид
Хоёр. Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх, хүнд суртал, чирэгдэлгүй арилгах чиглэлээр			
7	Зөвлөмж 18. Нийслэлийн Засаг даргын харьяа байгууллага болон Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв хоорондын уялдаа холбоог сайжруулах, төвийн цахим системд Засгийн газрын байгууллагуудыг холбох, төвөөс өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд хяналт тавих эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх арга хэмжээ авах	Төвөөр үйлчлүүлж байгаа иргэдэд ил тод, хүнд сурталгүй үйлчилж, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль болон Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/1086 дугаар захирамжаар батлагдсан "нийслэлийн нутгийн захирааны байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам"-ын дагуу өргөдөл гомдлыг түргэн шуурхай шийдвэрлэх	Нийт албан хаагчид
Гурав. Төсвийн орлого бүрдүүлэлт, зарцуулалтыг сайжруулах чиглэлээр			

8	Зөвлөмж 28. Төрийн албан хаагчдыг зөвхөн хуульд заасан үндэслэлээр ажлаас чөлөөлөх, үндэслэлгүйгээр ажлаас чөлөөлсний улмаас төсвийн төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулж байгаа зөрчлийг давтан гаргахаас сэргийлэх, хууль бус шийдвэр гаргасан тохиолдолд учруулсан хохирлыг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлэх	Энэ төрлийн зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлж ажиллах	Удирдлага
9	Зөвлөмж 29. Төрийн албан хаагчийн урамшуулалттай холбоотой зохицуулалтыг боловсронгуй болгох	Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангуулах	Бодлого төлөвлөлтийн хэлтэс
<b>Тав. Худалдан авах ажиллагааны тогтолцоог сайжруулах чиглэлээр</b>			
10	Зөвлөмж 42. Худалдан авах ажиллагааны бодлого, төлөвлөлт оновчтой бус, ил тод байдал хангалтгүй, гүйцэтгэлд тавих хяналт сул, хариуцлага тооцох эрх зүйн орчин боловсронгуй бус байгаа нь авлигын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл бүрдүүлж байгаад онцгой анхаарал хандуулах. Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөрийн 4.1.4.1, 4.1.4.2, 4.1.1.3-д тусгасан үйл ажиллагааг эрчимтэй хэрэгжүүлэх	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэн, төндөрийн материалд холбогдох материалыг бүрэн оруулж, дүнг холбогдох албан тушаалтанд тайлагнаж ажиллах	Удирдлагууд, Үнэлгээний хорооны гишүүд
11	Зөвлөмж 44. Худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн албан хаагчдын тоог нэмэгдүүлэх, тэднийг сургах, чадавхжуулах, төндөрийн үнэлгээний байнгын бус ажиллагаатай байхаар зохион байгуулах, үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд мэргэжлийн холбоод, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оролцуулах, тэдгээрийн хяналт тавих нөхцөлийг бүрдүүлэх	Худалдан авах ажиллагааны мэргэшсэн албан хаагчдын /А-3 сертификат/ тоог нэмэгдүүлэх чиглэлээр сургалтад хамруулах	Удирдлага
12	Зөвлөмж 45. Төндөрийн бичиг баримтын бүрдүүлэлт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, худалдан авах ажиллагааг хариуцсан ажилтан, үнэлгээний хорооны гишүүдийн ёс зүй, хариуцлагыг чангатгах, авилга, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх	Үнэлгээний хорооны гишүүд төндөр шалгаруулалттай холбоотой баримт бичгээр хууль, тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлж архивын ажилтанд хүлээлтэй өгөх, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж ажиллах	Үнэлгээний хорооны гишүүд
13	Зөвлөмж 47. Худалдан авах ажиллагаа /төндөр/-ны сонгон шалгаруулалтыг цахим хэлбэр шилжүүлэх	Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын худалдан авах ажиллагааг зохион байгуулах, мөн Сангийн сайдын 2017 оны 365 дугаар	Үнэлгээний хорооны гишүүд, Хяналт шинжилгээ, үнэлгээ

	тушаалаар батлагдсан "Худалдан авах ажиллагаанд дотоод аудит хийх журам"-ын дагуу төндөрийн материалд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах	харилцсан мэргэжилтэн
--	--	-----------------------

ХЯНАСАН:

ХЭЛТСИЙН ДАРГА *S. Bayarturayev* ГАНТҮШИГ

НЭЛТГЭСЭН:

МЭРГЭЖИЛТЭН *T. Odontogoo* Т. ОДОНТОГОО